

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-12

1.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	4-6
2.“Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	6-12
3.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	12

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 05 дугаар сарын 02-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 33 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адьяаа, Ц.Мөнх-Оргил;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Ц.Сандаг-Очир;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Сэргэлэн;

Тасалсан: Э.Бат-Амгалан, Н.Учрал.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Байнгын хорооны дарга Б.Энхбаяр “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын дараалалд оруулах талаар горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг хэлэлцэхээр болов.

Нэг.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бат.Баярмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн
42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгах санал:**

Б.Энхбаяр: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 46¹.1 дэх хэсгийн “Шаардлагатай” гэсний өмнө “Засгийн газар” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн “3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг,” гэснийг “3 дугаар зүйлийг,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, мөн Комиссын гишүүн Д.Сүнжид, Б.Энхболд, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Ц.Мөнхцэцэг нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, мөн Комиссын гишүүн Д.Сүнжид, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Б.Энхбаяр нар үг хэлэв.

Б.Энхбаяр: “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагааны

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Энхбаяр: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 35 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 12 цаг 08 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон
“Жанжсин Д.Сүхбаатар” танхим
11 цаг 33 минут.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023
ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
05 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР
МЯГМАР ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Б.Энхбаяр: ХЗБХ-ны 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаан гишүүдийн ирц олонх хүрэлцэн ирсэн учраас нээснийг мэдэгдье.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Энхбаяр гишүүн ирсэн байна. Адьшаа гишүүн ирээгүй байна. Алтанхуяг гишүүн чөлөөтэй. Бат-Амгалан гишүүн ирээгүй байна. Бямбацогт гишүүн ирсэн байна. Ганбат гишүүн ирсэн байна. Дэлгэрсайхан гишүүн ирсэн байна. Мөнхбаатар гишүүн ирсэн байна. Мөнх-Оргил гишүүн гадаад томилолттой. Мөнхцэцэг гишүүн ирсэн байна. Нямбаатар гишүүн ирсэн байна. Пүрэвдорж гишүүн ирсэн байна. Раднаасэд гишүүн ирээгүй байна. Сандаг-Очир гишүүн ирээгүй байна. Сүхбаатар гишүүн ирсэн байна. Сэргэлэн гишүүн өвчтэй. Учрал гишүүн ирээгүй байна. Цогтбаатар гишүүн ирсэн байна. Б.Энх-Амгалан гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1-д, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. ЗГ-аас 2023

оны 01 дүгээр сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

2 дугаарт, “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Алга байна.

Горимын санал гаргая. “УИХ-ын 2023 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард ХЗБХ-ны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлын дараалалд оруулж, хэлэлцүүлэх санал гаргаж байна. Энэ асуудлаа 5 сарынхаа цаглаварыг баталчихъя гэсэн ийм саналтай байна.

Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

54.5%-ийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Сайнзориг ХЗДХЯ-ны ТНБД, Д.Цолмон ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, Ш.Цолмон ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч, Х.Эрдэм-Ундрах Хууль зүйн үндэсний

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хүрээлэнгийн захирал гэсэн албан тушаалтнууд оролцож байна.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг гишүүдэд тараасан байгаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Хуулийн төсөлтэй холбогдон гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулъя. 2 санал байна.

1.Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгах санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 46¹-ийн 1 дэх хэсгийн “шаардлагатай” гэсний өмнө “Засгийн газар” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр гэсэн байна.

Энэ бол 42.2.3-д заасны дагуу 3-ны 2-оор санал хураах ёстой. Яагаад гэхээр орчуулга хийж болно гэххэд яг хэн орчуулахыг нь бичээгүй орхичхож. Тэгэхээр ЗГ мэдээж үүнийг тавина аа гэдэг ийм санал гаргаж байгаа юм. Санал хураалт.

72.7%-ийн саналаар санал дэмжигдлээ.

2 дахь санал. Төслийн 6 дугаар зүйлийн “3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг” гэснийг “3 дугаар зүйлийг” гэж өөрчлөх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Энхбаяр. Санал хураалт.

72.7%-ийн саналаар санал дэмжигдлээ.

1 зарчмын зөрөөтэй санал гаргах гэсэн боловч энэ УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42

дугаар зүйлийн 42.2.1. нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсэн гэдэг үндэслэлээр санал хураалгай гээд тэгэхээр энэ асуудлаар анхны хэлэлцүүлгээр чуулган дээр санал хураагдаагүй юм байна, 1 дүгээрт, санал гараагүй.

2 дугаарт, санал хураалт явагдаагүй учраас нөгөө санал хураалт явуулахгүйгээр гүйцээн боловсруулах гэдэг ийм асуудал байхгүй болчихоод. Тэгэхээр нөгөө би хураалгах гэхээр би өөрөө дэг зөрчсөн асуудалд орчих гээд байна.

Би чинь хуульч хүн шүү дээ, би чинь хуульч хүн шүү дээ гэж. Тийм учраас санал хураалт явуулж дууслаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд УИХ-ын гишүүн хэн танилцуулах вэ? Гишүүдээс, саналаараа, хууль тогтоомж байвал.

Дэлгэрсайхан гишүүн танилцуулъя.

11.43 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

“Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хунан ХЭҮК-ын дарга, Сүнжид ХЭҮК-ын гишүүн, Энхболд ХЭҮК-ын гишүүн оролцож байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү.

Энэ техникийн саатал гараад байх шиг байна шүү. Техникийнхээ энэ юу гараад ирчхэв, дэлгэц дээр. Энэ техникийн асуудал гараад түр явж байна.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93.1-д УИХ шийдвэр гаргахаар хууль тогтоомжид заасан болон хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа зохион байгуулалтын шинжтэй асуудлын талаар хариуцсан байгууллага, эрх бүхий албан тушаалтанд саналаа ирүүлсэн бол холбогдох Байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлтээ шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна гэж заасан.

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 9.2-т комиссын илтгэлийг жил бүрийн УИХ-ын хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, илтгэлээр өгсөн санал зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар УИХ тогтоол гаргана гэж заасан байна.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа.

Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Д.Цогтбаатар: Гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе. Тэгээд энэ ёстой

чухал асуудал орж ирж байгаа. Тэгээд энэ тогтоолыг дэмжиж байгаа. Ялангуяа энэ дотроо энэ иргэний халдашгүй байдал, халдашгүй чөлөөтэй байх эрхийн талаарх нэлээн заалтууд орж ирсэн байна. Энэ бол маш чухал. Тэгээд үүнтэй холбогдуулж нэг хэдэн зүйл хэлмээр байгаа юм.

Үнэхээр энэ улсад иргэдийнхээ энэ чинь хуулиар иргэд халдашгүй эрхтэй байхгүй юу. Тэгэхэд ингээд л гишүүний дархан эрх гээд л ёстой мянган юм ярих юм. Би сүүлдээ ингэж бодож байгаа юм. Ер нь энэ УИХ тэгж иргэнийхээ л халдашгүй байдлыг ярина уу гэхээс энэ гишүүдийн дархан эрх эд нар гэдэг юмыг бүр дараагийн Их Хурал хүртэл гишүүд тэгвэл өөрсдөө дархан эрхээсээ татгалзчих хэрэгтэй. Яагаад гэвэл ийм байдалтай дархан эрх чинь дархан эрх биш бүр лай болж байгаа юм. Тэгээд энэ дээр нэг юу гарч байгаа асуудал нь юу вэ гэхээр хэрэв ингэх юм бол бид нар харин дараагийнхаа Их Хурал дээр дараагийн Их Хурлын гишүүдээс ийм юм битгий шаардаж байгаарай. Яагаад гэвэл энэ Их Хурлын гишүүний дархан эрхэд чинь иргэдийн үг хэлэх эрх чөлөө чинь өөрөө давхар хамгаалагдсан. Яагаад гэвэл иргэдийн өмнөөс тэр үгийг нь дамжуулж хэлж байдаг учраас хамгаалагдсан байдаг учраас. Тэр чинь тэр гишүүний эрх биш сонгогчдын эрхийн асуудал явж байгаа юм аа гэдгийг ярих эрх зүйн юу тэгээд ёс суртахууны үндэс гарч ирж байгаа юм. Тэгэхгүй бол одоо бид нар ийм юм ярих юм бол эд нар өөрсдийгөө хамгаалаад байна гэдэг асуудал гарах учраас үүнийг энэ өнцгөөс нь бараг ярих нь зөв байх гэж бодож байгаа юм.

2 дахь яг үүнтэй холбогдуулаад ер нь энэ юу, гишүүд дурьд юмаа ярьдаг. Үүнээсээ болоод хариуцлага хүлээдэггүй байх энэ асуудал дээр бид нар цэг тавих ёстой. Энэ гишүүд хамгийн хариуцлагатай юм ярьдаг албан тушаал дээр байгаа хүмүүс. Яагаад иргэд ярьсан юмандаа хариуцлага хүлээгээд байхад хамгийн хариуцлагатай байх албан тушаалтнууд ямар ч үндэслэлгүй юм

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ярьчихаад тэгээд ямар ч хариуцлага хүлээхгүй яваад байж болдог. Тэгэхээр л тийм хариуцлагагүй юм ярьчихсанаах дараа дархан эрхээр хамгаалагдах гээд байгаа байхгүй юу. Бас давхар энд чинь. Тэгэхээр энэ юмнуудыг ярих ёстой. Энд тэгэхээр иргэдийн энэ халдашгүй чөлөөтэй байдлын асуудал орж ирж байгаа нь сайн.

Энд бас нэг юу яригдаж байгаа асуудал бол энэ жагсаал цуглаан хийх журмын тухай хууль, хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг оруулж ир ээ гэсэн заалт орсон байна. Энэ маш чухал аа. Өнөөдрийн энэ яригдаж байгаа энэ залуусын яриад байгаа бас асуудлыг үнэхээр түргэн авч үзээд, ялангуяа Хүний эрхийн комиссынхон маань энэ хуулийг нь оруулж ирэхээр энэ иргэдийн үгээ хэлэх эрх чөлөөг нь баталгаажуулах тал дээр та нар анхаарч явахгүй бол зүгээр дугуй байж байж үүний ард үгээ хэлэх эрх чөлөөтэй оронд төр нь дугуй байж ард нь гарна гэж байхгүй шүү. Тэгэхээр заавал энэ хийх ёстой арга хэмжээг авах ёстой. Та нар бол, би хэлээд байгаа шүү. Дарга нарт “үгүй” гэж хэлж сурах хэрэгтэй. Тэгээд та нар хийх ёстой ажлаа төрд таалагдахгүй байх тусам нь та нар харин ажлаа хийж байх ёстой гэдэг л би санааг хэлмээр байна. Баярлалаа. Асуулт байхгүй.

Б.Энхбаяр: Мөнхцэцэг гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнхцэцэг: Энэ манай ХЭҮК-ын 22 дахь удаагийн тайлан илтгэл дээр энэ үндэслэлгүй баривчлан хорих, цагдан хорих мөн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар тодорхой зүй зөвлөмж, статистик мэдээнүүд орсон байна. Энэ бол их чухал асуудал.

Миний бие Хүний эрхийн дэд хорооны даргын ажлыг аваад 4 сар болж байна. Энэ хугацаандаа манай Хүний эрхийн дэд хороон дээр ирсэн гомдлуудын бараг 80 орчим хувь нь шүүхийн

зөвшөөрөлгүйгээр цагдан хоригдсон, баривчлагдсан мөн мөрдөн байцаах шатандаа тодорхой асуудлаар эрүүдэн шүүсэн байх магадлалтай ийм өргөдөл гомдлууд дийлэнх нь ирсэн байна. Тэгэхээр энэ манай УИХ-аас гарах ийм тогтоол дээр нь ийм чиглэл байгаа. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах, бие даасан бүтэц байгуулах асуудлыг судлан танилцуулах гэдэг ийм тогтоолын төсөл гарч байгаа. Тэгэхээр энэ дээр манай энэ Хүний эрхийн комисс бол эрүүдэн шүүх үндэсний хараат бус комиссарын байр суурь ямар байдаг вэ?

Монгол Улс эрүүдэн шүүхийн эсрэг нэмэлт 2 дугаар протоколд нэгдэн орсон. Үүнийхээ үндсэн дээр Монгол Улс хараат бус эрүүдэн шүүхийн эсрэг ийм институт байгуулах ёстой. Хуучны манай нэлээд олон шүүгчид, хуульчдын дунд ярьдгаар нөгөө Прокурорын дэргэдэх мөрдөн байцаах албыг татан буулгасан нь эрүүдэн шүүх гэмт хэргийг өгшүүлэх, эрүүдэн шүүсэн тодорхой албан тушаалтанд хариуцлага тооцох механизмыг их бүдгэрүүлээ гэж шүүмжилдэг юм аа. Энэ дээр та бүхний байр суурь ямар байдаг бол?

Ер нь Хууль зүйн яамнаас Мөрдөн байцаах албаны тухай хуулийг өргөн барина аа. Үүн дотор энэ мөрдөн байцаах алба тэр дотор эрүүдэн шүүхийн эсрэг хараат бус тогтолцоог бий болгоно гэдэг ийм байр суурийг хэлээд байгаа. Үүнийг 1 дүгээрт асууя.

2 дугаарт нь, тэр нөгөө ахмадын эрхийн зөрчилтэй холбоотойгоор нийгмийн даатгалын болон тэтгэврийн хуулиудад тодорхой заалтуудыг оруулаач ээ гэдэг ийм тайлан комиссын илтгэлд байгаа. Тэгээд үүнийг өшөө тодруулж асуумаар байна. Одоо Их Хурлаар хэлэлцэж байгаа нийгмийн даатгалын багц хуулиас гадна бусад ахмад настны хөгжих болон ахмад насны хөдөлмөрлөх эрхүүдийг хамгаалах тал дээр өөр ямар

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

шинэчлэл шаардлагатай байгаа вэ гэдэг комиссын манай гишүүдээс асууя.

Б.Энхбаяр: 2 номерын микрофон.

Я.Цэлмэн: Баярлалаа. Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Эрүүдэн шүүсэн, эрүүдэн шүүх гэмт хэргийг хараат бусаар шалган шийдвэрлэх бие даасан албыг байгуулах энэ санал орж ирж байгаад баяртай байна. Энэ дээр Ю Пи Ар буюу хүний эрхийн энэ зөвлөлийн 2020 онд болсон Монгол Улсын энэ тайланг хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний 3 дугаар илтгэлийг хэлэлцүүлэх үеэр бусад орнууд яг энэ албыг байгуулах талаар саналуудыг өгч байсан байдаг. Ялангуяа энэ өгч байсан улсуудаас дурдах юм бол жишээ нь Мексик байна. Эрүүдэн шүүлттэй холбоотой гомдлыг шалгадаг, бие даасан, үр дүнтэй процедур бий болгох гэсэн. Франц байна. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр зүй бусаар харьцсан тухай гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх үр дүнтэй механизм бий болгох гээд. Ингээд нийтдээ Монгол Улсад 170 орчим зөвлөмж өгсний нэлээдгүй хувийг яг энэ эрүү шүүлттэй холбоотой асуудал дээр тодорхой үр дүнтэй механизм байгуулах, энэ албыг үр дүнтэйгээр зохион байгуулах гэсэн ийм зөвлөмжийг өгдөг.

Тайланд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд хийсэн хяналт шинжилгээ, холбогдох прокурорын байгууллага бусад шүүхийн байгууллагаас авсан дүн мэдээгээр 2017-2022 оны байдлаар нийт 385 гомдол ирсэн байдаг. Хуулийн байгууллагуудад эрүү шүүлттэй холбоотой. Ингээд үүнтэй холбогдуулж 471 хүн шалгагдсанаас шүүхээр шийдвэрлэгдэх шатандаа 19 онд 3 хэрэг шийдвэрлэгдсэн, 20 онд 3, 21 онд 3 ингээд 22 онд 3 хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн байгаа. Тэгэхээр анх ирж байсан гомдол шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо мэдээ 2-ын хооронд бас нэлээн зөрөө байгаа. Тэгэхээр энэ албыг байгуулах нь гарцаагүй чухал байгаа юм аа гэдэг нь энэ дүн мэдээгээр харагдаж

байгаа. Ер нь мэргэшсэн байх нь өөрөө бас олон улсын жишиг шаардлага юм байна лээ. Яг эрүү шүүлттэй холбоотой энэ асуудал бол. Яагаад гэхээр эрүү шүүлт явуулдаг нөгөө эсрэг талын субъект маань ингээд төрийн хууль сахиулах эрх бүхий алба хаагч нар ингээд байдаг учраас энэ тогтолцооны эсрэг маш хүчтэй ийм мэргэшсэн алба байх нь үр дүнгээ өгнө өө гэж ингэж олон улсаас манай улсад өгсөн зөвлөмж дээр бас тусгасан байгаа. Тийм учраас бас энэ саналыг оруулсан. Баярлалаа.

Б.Энхбаяр: 4 номер Хунан дарга.

Ж.Хунан: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр ХЭҮК эрүү шүүлт тулгах гэмт хэргийг мөрдөн шалгах хараат бус бие даасан байгууллага байгуулахтай холбоотой ямар байр суурьтай байдаг вэ гэж асуулаа. Тэгэхээр комиссын зүгээс эрүү шүүлт тулгах, мөрдөн шалгах, бие даасан хараат бус байгууллага байгуулах асуудлыг бүрэн дэмждэг. Өөрөөр хэлбэл олон удаагийн илтгэл болон тусгайлан санал энэ бие даасан мөрдөн шалгах ийм байгууллагыг байгуулах нь зүйтэй гэдгийг илэрхийлж байгаа.

Монгол Улс эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмаа байгуулсан. 2014 онд нэмэлт протоколд нэгдэж ороод урьдчилан сэргийлэх механизмаа 2020 оны хуулиар байгуулсан. Одоо бол энэ бие даасан байгууллага байгуулах асуудлыг бас судалж шийдвэрлэх ийм саналыг бас оруулж байгаа.

Б.Энхбаяр: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Мөнхцэцэг гишүүний асуултад 5 номерын микрофон гүйцээж хариулъя.

Д.Сүнжид: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулъя гэдэг

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

санал өгч байгаа. Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулъя гэдэг санал өгч байгаа. Ахиад Хөдөлмөр эрхлэлт дийг дэмжих тухай хуульд ахмадуудад ажлын байр бий болгох чиглэлээр хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой бас санал нэмье ээ гэдэг ийм саналыг өгч байгаа. Ахиад НДШ болоод татвартай холбоотой асуудлаар хэрвээ ахмадуудад ажлын байр бий болгосон бол ажил олгогчид ямар татварын хөнгөлөлт, даатгалын хөнгөлөлт эдлүүлэх вэ гэдэг талаар бас нэмэлт, өөрчлөлт оруулах ийм саналуудыг тусгасан.

Б.Энхбаяр: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу? Би үг хэлнэ, надаар тасаллаа. Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа.

Мөнхцэцэг гишүүн үгээ хэлье.

Ц.Мөнхцэцэг: Монгол Улс Ази дахинд ардчилал, хүний эрхийн үзүүлэлтүүдээрээ нэлээд өндөрт явж байгаа. Тэр дотроо 1990 онд нэг гараанаас гарсан пост коммунист орнууд дотроо ардчилал, хүний эрхийн үзүүлэлтээр маш толгой цохиж явж байгаа орны хувьд хүний эрхийн тодорхой асуудлаарх одоо хүртэл шийдэгдэхгүй байгаа энэ зөрчил, хүний эрхийн үзүүлэлтүүдийг хойш нь татаж байгаа тодорхой асуудал дээр Монголын төрөөс анхаарах шаардлагатай байна аа. Тухайлан энэ дээр энэ хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчиж байгаа Эрүүгийн хуулийн ЭХХШТХ-ийн тодорхой заалтууд, хэт ерөнхийлөн орсон хүний эрхийг зөрчих магадлалтай субъектив дүгнэлт гаргахуйц ийм хуулийн заалтуудыг бид нар дахин эргэн харж, эрх зүйн хэрэглээний давхардал гаргахгүй хуулийн хийдэл гаргахгүй байх тал дээр анхаарах шаардлагатай.

2 дугаарт нь, энэ хүний эрхийн түгээмэл асуудлуудын нэг болох хөдөлмөрлөх эрх тэр дотроо энэ төрийн үйлчилгээний болон тусгай албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн асуудлыг бас илүү харах шаардлагатай байгаа нь одоо энэ ХЭҮК-ын 22 дахь энэ тайлан илтгэлээс харагдаж байна. Тухайлан онцлон хэлэх юм бол тусгай салбарууд болох хил хамгаалах онцгой байдлын албан хаагчид тэдгээрийн нийгмийн баталгаа, үнэлэмж, цалин хөлсний нөхцөл байдал зэргийг эргэн харах шаардлагатай байна.

Мөн их онцгой нөхцөл буюу улсын хил дээр үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдын гэр бүлийн асуудал, нийгмийн асуудал зэргийг холбогдох хуулиудаар онцгойлон зохицуулах шаардлагатай байна. Тухайлбал илтгэлд дурдсанаар хилийн цэргийн албан хаагчид онцгой нөхцөл гэдгээрээ харьцангуй эрт тэтгэвэрт гардаг хэдий ч түүний гэр бүлийн гишүүд нь жирийн ердийн нөхцөлөөр тэтгэвэрт гарах зэргээрээ тэтгэвэрээ үнэлүүлэх улсад хийсэн хөдөлмөрөө үнэлүүлэх тал дээр бас тодорхой ийм тэгш бус байдал гарч байна. Тэгэхээр энэ дээр бас онцгойлон ийм тодорхой хууль зүйн болон зохицуулалт хийх шаардлагатай байгаад байна.

Мөн тэр эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар Монгол Улс Монголын төрөөс зөвлөлдөх шаардлагатай байна аа. Бидний олон түмэнд хамгийн тод мэдэгдэж байгаа эрүүдэн шүүсэн гэмт хэрэг хүлээлгэж, хилсээр хэлмэгдүүлсэн тодорхой ноцтой кэйс энэ талийгаач Зориг агсны амь насыг бусниулсан хэрэгт холбогдож, 3 шүүхээс ял авсан иргэн Чимгээ болон Содномдаржаа нарын хэрэг байгаа. Эдгээр иргэдийг эрүүдэн шүүж гэмт хэргийг хүлээлгэсэн, хилсээр шүүгдсэн гэдгийг Монголын шүүх саяхан тогтоосон. Тэгвэл цаашид бид нар хэн ч Монгол Улсын иргэнийг эрүүдэн шүүж, хууль бусаар гэмт хэргийн хүлээлгэх ийм

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

нөхцөлийг гаргахгүй байх ёстой. Тийм учраас Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцынхоо дагуу эрүүдэн шүүхийн эсрэг үндэсний тэр хараат бус институцийг яаралтай байгуулах нь шаардлага байгаад байна.

Мөн боловсролын эрхийн асуудал. Хүний эрхийн энэ удаагийн тайланд бас онцгойлон дурдагдсан байна. Дотуур байранд буюу эцэг эхээсээ удаан хугацаагаар хол байгаа хүүхдийн сурч боловсрох, эрүүл аюулгүй орчинд сургалтын ажиллагаа авах, хөгжих эрх нь зөрчигдсөн байгаад байна. Энэ тал дээр улсын Боловсролын яам мөн төсвийн бодлого дээрээ анхаарах шаардлагатай байна. Боловсролын хууль дээр тодорхой төсвийг нь орон нутаг болон улсын төсвөөс хуваалцан гарахаар ийм саналууд орж ирсэн. Үүнтэй миний санал нийлэхгүй байгаа. Монголын Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй болох ёстой гэдэг. Тийм учраас улсын төсвийг дотуур байрны бүх зардал, дотуур байр болон ЕБС-д сурч байгаа бүх хүүхдийн төсвийг бүгдийг нь улсын төсөв гаргах шаардлагатай. Тэгж байж бид нар тэнд сурч байгаа хүүхдийнхээ эрүүл аюулгүй орчинд сурах, чанартай боловсролоор тэгш хангагдах эрхийг хангах болно оо. Энэ тал дээр ингээд манай Боловсролын байнгын хороо бас хэлэлцэж байгаа хуульд илүү анхааран ажиллах шаардлагатай байгаа гэдгийг бас хэлмээр байна.

Ингээд мөн сүүлийн жилүүдэд энэ жагсаал цуглааны давтамж ихсэж, иргэдийн маань үзэл бодлоо илэрхийлэх иргэн өргөн хүрээтэй тохиолдлууд нэмэгдэж байна. Үүнтэй холбоотойгоор тодорхой заалтууд маань тухайлбал Жагсаал, цуглааныг зохицуулах тухай хуулийн тодорхой заалт хоцрогдож байна аа. Тийм учраас бид нар олон улсын хүний эрхийн стандартад нийцсэн байдлаар энэ жагсаал, цуглааныхаа хууль тогтоомжийг шинэчлэх шаардлагатай байна.

Мөн аяндаа үүссэн жагсаал, мөн ганцаараа хийж байгаа улс төрийн эсэргүүцэл хөдөлгөөнүүдийг өнөөг хүртэл эрх зүйн хувьд зохицуулалтгүй байгаа. Тодорхой одоо цагдаагийн байгууллагын зүгээс тухайн жагсаал болон ганцаараа хийж байгаа иргэний тэмцлийг хууль бус гэдэг байдлаар тараах тодорхой кэйсүүд дээр микрофон болон бусад зүйлийг хураах явдал гарсан. Тийм учраас цаашид бид нар энэ иргэнийхээ үзэл бодлоо илэрхийлэх, жагсан цуглах эрхийг хамгаалах, үүний тулд Европын болон олон улсын стандарт илүү ойртуулах шаардлагатай байгаа.

Энэ тал дээр бас манай УИХ болон ХЭҮК хэрэгжилт дээр бас анхаарал тавьж ажиллах ёстой гэдгийг хэлмээр байна.

Б.Энхбаяр: Баярлалаа. Би нэг бас гишүүнийхээ хувьд хэдэн үг хэлье.

Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх ХЭҮК-ын 22 дахь илтгэлийг ХЗБХ 2 өдрийн турш хагас сонсгол хэлбэрээр дэлгэрэнгүй хэлэлцсэн. УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар мөн хэлэлцсэн. Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн мөн Хүний эрхийн Комиссын гишүүний тайланг хэлэлцсэн. Ингээд УИХ-аас тогтоол гаргах шаардлагатай гэж үзсэн.

Энэ тогтоол энэ ХЭҮК-оос гаргасан тайлан илтгэлтэй холбоотойгоор мөн ХЗБХ-оор энэ илтгэлийг хэлэлцэх явцад гарсан олон саналуудыг тусгаж, нэлээн том хэмжээний тогтоол гарах нь зүйтэй гэж үзсэн. Ямар асуудлуудыг тусгаж байна вэ гэж. Тухайлбал халдашгүй чөлөөтэй байх эрхийн хүрээнд сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцод нийцүүлэх арга хэмжээ авах чиглэлээр хуулийн төслийг өргөн барь аа гэж ЗГ-т даалгаж байна.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Шүүхийн зөвшөөрөлгүй сэжигтнийг баривчлах шийдвэр бүрийн үндэслэл шалтгааныг хэлэлцдэг шүүхийн хэлэлцүүлгийг бий болгох, хууль бусаар баривчлагдсан сэжигтнийг судалгааг тогтмол гаргаж, холбогдох алба тушаалтанд хариуцлага хүлээлгэдэг байх, тухайн хүн өөрийг нь баривчилсантай холбоотой баримт материалыг холбогдох байгууллагаас гаргуулан авах эрх зүйн зохицуулалтын талаар санал боловсруулахыг ЗГ-т даалгаж байна.

Цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авах нийтлэг журам, цагдан хорих үндсэн болон сунгах хугацаа, өсвөр насны яллагдагчийг цагдан хорих тусгай журам, цагдан хорих үндэслэлд хамаарах хэт ерөнхий болон өргөжүүлсэн зохицуулалт, шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн шатанд таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх асуудлыг нарийвчлан зохицуулсан хуулийн төсөл боловсруулж, өргөн барихыг ЗГ-т мөн даалгаж байна.

Цагдан хорих байранд гүйцэтгэх ажил, нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүрээг хязгаарлаж, хүний эрхийн зарчимд нийцүүлэн зохицуулалтыг боловсронгуй болгох саналаа танилцуулахыг мөн ЗГ-т даалгаж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд таслан сэргийлэх арга хэмжээний зөвшөөрлийг шуурхай шийдвэрлэх чиг үүрэгтэй зөвшөөрлийн шүүх бий болгох асуудлаар санал бэлтгэж, танилцуулахыг мөн ЗГ-т даалгаж байна.

Үндэсний аюулгүй байдлыг хангах болон шүүхэд нотлох баримтаар үнэлэгдэх зарим төрлийн гэмт хэргийг илрүүлэх зорилгоор нууц гүйцэтгэх ажил мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах эрх зүйн зохицуулалтыг тусгасан хуулийн төслийг УИХ-д өргөн барихыг ЗГ-т даалгаж байна.

Хүүхдийн эрхийн асуудлаар, ахмад настны эрхийн асуудлаар, эрүүдэн

шүүхээс урьдчилан сэргийлэх асуудлаар чиглэсэн Хүний эрхийн комиссын саналыг тусгасан цогц арга хэмжээг авахыг мөн даалгаж байна.

Эрүүдэн шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан бүтэц байгуулах асуудлыг танилцуулахыг ЗГ-т мөн даалгаж байна.

Монгол Улсын Үндсэн хууль иргэний үндсэн эрхийн суурь үзэл баримтад нийцүүлэн жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан УИХ-д өргөн барихыг мөн ЗГ-т даалгаж байна.

Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж, авч хэрэгжүүлэх арга хэмжээг нэгдмэл байдлаар тодорхойлж, цалинг төрийн албаны цалинг инфляцын түвшинтэй уялдуулан үе шаттай нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг мөн ЗГ-т даалгасан.

Ийм тогтоолын төслийг гарах нь зүйтэй гэж үзсэн байгаа.

Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан.

Одоо тогтоолын төслийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

66.7%-ийн саналаар тогтоолын төслийг дэмжлээ.

Санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд УИХ-ын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Мөнхцэцэг танилцуулна.

12.06 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

“УИХ-ын 2023 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард ХЗБХ-ны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

“Монгол УИХ-ын 2023 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард ХЗБХ-ны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

58.3%-ийн саналаар тогтоол батлагдлаа.

12.08 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Гишүүддээ баярлалаа.

**Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ